



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 51

Арвайхээр

Амьжиргааг дэмжих зөвлөлийн 2017 оны  
үйл ажиллагааг үнэлэх тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 20.1.2, "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 27.6, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны а/89 дүгээр тушаалаар батлагдсан "Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм"-ийн 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, мэдээллийг хэлэлцэж, иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх ажлын үр дүнг "Хангалттай" гэж үнэлсүгэй.

2. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөл болон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хамтын ажиллагааг сайжруулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын Захирагч /О.Пүрэвдорж/, Амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга /В.Шоовдор/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН